# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 48 (573)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2008 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2008 оны арванхоёрдугаар сарын 28 №48 (573)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | | |
|---|---|---|---|
| 755. | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1274 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 756. | Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай | Дугаар 42 | 1274 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 757. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 356 | 1275 |
| 758. | ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 357 | 1278 |
| 759. | Түдэвлунцагийн Нямжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай | Дугаар 358 | 1278 |
| 760. | Дамчаагийн Бямбаад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай | Дугаар 359 | 1279 |
| 761. | Жамъянгийн Банзрагчид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 360 | 1279 |
| 762. | Жамъянжавын Дамдинжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 361 | 1279 |
| 763. | Тойвгоогийн Очирхуягт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай | Дугаар 362 | 1279 |
| 764. | Цогзолын Дагвадоржид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 363 | 1280 |
| 765. | Гончигсүрэнгийн Пүрэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 364 | 1280 |
| 766. | Зоригтын Ганбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 365 | 1280 |
| 767. | Галцогтын Галбаатарт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 366 | 1280 |
| 768. | Дамдингийн Цэрэннадмидад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 367 | 1281 |
| 769. | Монхооны Жавхлантуяад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 368 | 1281 |

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 770. | Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 30 | 1281 |
| 771. | Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Дугаар 31 | 1282 |
| 772. | Сургалт, семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай | Дугаар 32 | 1283 |
| 773. | Журамд нэмэлт оруулах тухай | Дугаар 34 | 1284 |
| 774. | Хөрөнгө гаргах тухай | Дугаар 37 | 1284 |
| 775. | Хэнтий аймгийн Бэрх тосгонд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 45 | 1285 |
| 776. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 47 | 1285 |

### Тав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 777. | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 45 | 1286 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 11-ний өдөр — Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ "**4 дүгээр зүйл. Сангийн хөрөнгийн байршил**

4.1.Сангийн мөнгөн хөрөнгийг Төрийн санд байршуулна.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан мөнгөн хөрөнгийг Монголбанк, Засгийн газрын нэгдсэн саналаар санхүүгийн зах зээл дээр байршуулж болох бөгөөд ийнхүү байршуулсан хөрөнгийн хүүгийн хэмжээ болон эрсдлээс хамгаалах арга хэрэгслийг Засгийн газраас Монголбанктай байгуулсан гэрээгээр зохицуулна.

4.3.Энэ хуулийн 4.2-т зааснаар хөрөнгийг байршуулах журмыг Засгийн газар батална. Энэхүү журмын хэрэгжилтэд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хяналт тавина."

**2 дугаар зүйл**.Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2008 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 11-ний өдөр — Дугаар 42 — Улаанбаатар хот

### Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарим хэсгийг хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах тухай

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гурилын хангамжийг сайжруулах, үнийн өсөлтөөс сэргийлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/ 2008 оны дотоодын ургацаас 100 мянган тонн хүнсний буудайг худалдан авч, Монгол Улсыг хөгжүүлэх санд буудайн нөөц хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах;

2/Монгол Улсыг хөгжүүлэх санд байршуулсан хүнсний буудайг 2009 оноос эхлэн жил бүрийн 2, 3 дугаар улиралд борлуулж, тухайн жилийн намрын ургацаас худалдан авч дахин байршуулах арга хэмжээг зохион байгуулж байх;

3/Монгол Улсыг хөгжүүлэх санд нөөц хэлбэрээр байршуулах хүнсний буудайг хадгалах байршил, түүнд байршуулах хүнсний буудайн хэмжээг тогтоох, түүнчлэн худалдан авах, борлуулах, хадгалах үйл ажиллагааг зохицуулах журам баталж, мөрдүүлэх.

2.Монгол Улсыг хөгжүүлэх санд хүнсний буудайн нөөц хэлбэрээр байршуулах 100 мянган тонн хүнсний буудайг худалдан авах, тээвэрлэх, хадгалах зардалд шаардагдах 40 тэрбум төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц. Баярсайхан/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 356 | Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, уул уурхай , эрчим хүч, тээвэр, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

#### СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Халзхүүгийн Наранхүү - Монгол Улсын Их Хурлын гишүүн, уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн дарга асан

#### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Гончигийн Баттогтох - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн хангамжийн инженер
2. Хөхийн Буянхишиг - Орхон аймгийн Баян-Өндөр сумын МАХН-ын хорооны дэд дарга
3. Шаравын Гэзэгт - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн дарга
4. Рэнцэнгийн Дэлгэр - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн дарга

#### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Пүрэвийн Алтантулхүүр - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүний нөөцийн хэлтсийн хүний нөөцийн менежер
2. Дамдинсүрэнгийн Андрей - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн "Хангарьд" спорт клубийн ахлах дасгалжуулагч
3. Будлангийн Баатар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн материал техникийн хангамжийн хэлтсийн менежер
4. Ноолойн Баасандорж - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Дулааны станцын засварчин
5. Лхамсүрэнгийн Баасанжав - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн химийн шинжилгээний лаборант
6. Найданжавын Бадарч - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын жолооч
7. Цахиагийн Балдорж - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Засвар механикийн заводын хэсгийн дарга
8. Гэндэнжамцын Баярсайхан - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн механик засвар, бигнүүрийн хэсгийн дарга
9. Дангаагийн Ганбат - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Ерөнхий захирлын худалдаа эрхэлсэн орлогч
10. Чойдогийн Ганболд - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн
11. Гүн-Аагийн Гүнчинсүрэн - Орхон аймгийн "Баян-Өндөр" цогцолбор сургуулийн ерөнхий захирал
12. Дамбын Аюурзана - Орхон аймгийн "Баян-Өндөр" цогцолбор сургуулийн дуу хөгжмийн багш
13. Сүхбаатарын Дандар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Эмнэлэг сувиллын албаны ерөнхий эмч
14. Дэмбэрэлийн Даш - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн материал техникийн хангамжийн хэлтсийн менежер
15. Эрдэнэ-Очирын Доржболд - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн засварын хэсгийн тоног төхөөрөмжийн засварчин
16. Шаравын Доржготов - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Материал техникийн хангамжийн баазын мастер
17. Лхагваагийн Ичинлхам - УБТЗ-ын Эрдэнэт өртөөний жижүүр
18. Сүрэнхорын Ичинхорлоо - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн нягтлан бодох хэлтсийн нягтлан бодогч
19. Нигметийн Кадирбек - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн захиргааны

ерөнхий эрчим зүйн хэлтсийн тэргүүлэх дулаан зүйч

20. Галдангийн Ламжав - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн ахлах мастер

21. Дашийн Лхагваа - Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч, зөвлөх эмч

22. Жадамбын Лхагва - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн тооцоолон бодох техникийн цехийн дарга

23. Жамбаачүлтэмийн Мягмарсүрэн - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Төмөр замын цехийн эрчим зүйч

24. Доржийн Намжилдорж - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын ерөнхий эрчим зүйч

25. Чүлтэмийн Нямдалай - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Эрчим хүчний цехийн тоног төхөөрөмжийн засварчин

26. Магсарын Нямсүрэн - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны хэлтсийн дарга асан, ахмад ажилтан

27. Ванчигдоржийн Өлзийхутаг - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн даргын үйлдвэрлэл, техник хариуцсан орлогч

28. Бямбажавын Пүрвээ - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын БелАЗ-ын жолооч

29. Тогтохын Санах - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Засвар механикийн заводын цахилгаан гагнуурчин

30. Должавын Сайнбуян - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Дулааны станцын зуухны машинч

31. Содовын Сүхбаатар - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Технологийн автомат ба тооцоолон бодох техникийн цехийн тэргүүлэх инженер

32. Цэдэнхүүгийн Туяа - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төвийн орлогч дарга

33. Лхагважавын Хөхөө - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн зөвлөх инженер

34. Зундуйн Хэнзээ - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн баяжуулах фабрикийн засварын хэсгийн дарга

35. Доржготовын Цагаан-Эрдэнэ - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн дотоод тээврийн албаны хэсгийн дарга

36. Доржийн Цогтсайхан - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Геологи хайгуулын ангийн эрчим зүйч

37. Должийн Цогтхангай -Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Захиргаа ерөнхий механикийн хэлтсийн инженер-металлургич

38. Минжүүрийн Цолмон - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн эдийн засгийн хэлтсийн эдийн засагч

39. Дашийн Чулуунцэцэг - УБТЗ-ын Эрдэнэт өртөөний жижүүр

40. Бүдбазарын Шийдэв - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн харьяа Технологийн сургуулийн Байгалийн ухааны профессорын багийн профессор

41. Дамдинсүрэнгийн Эрдэнэдалай - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Үйлдвэр техникийн хэлтсийн инженер

42. Пионерийн Эрдэнэцогт - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирлын Хөгжлийн асуудал эрхэлсэн орлогч

## ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Үвдэлийн Сүрэнхорлоо - Орхон аймгийн Баян-Өндөр сумын өндөр настан
2. Гэлэгсампилын Ядамсүрэн - Орхон аймгийн Баян-Өндөр сумын өндөр настан

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Жаахүүгийн Адъяахүү - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн өөрөө нунтаглах хэсгийн тээрмийн машинч

2. Агваанцамжилын Алтанцаг - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн хэмжил зүйн ахлах инженер

3. Түмэн-Аюушийн Батмөнх - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн үйлдвэр техникийн албаны тэргүүлэх инженер

4. Сүхбаатарын Баттөр - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын жолооч

5. Авирмэдийн Баярсайхан - Орхон аймаг дахь улсын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эрчим хүчний цехийн хэсгийн дарга

6. Дашзэвэгийн Буяннэмэх - УБТЗ-ын Эрдэнэт өртөөний техник үйлчилгээний газрын вагон хариуцсан орлогч дарга

7. Намхайн Ганчимэг - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Технологийн автоматик ба тооцоолон бодох техникийн цехийн арга зүйч- инженер

8. Дамдиндоржийн Ганчимэг - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн нягтлан бодох хэлтсийн нягтлан бодогч

9. Мижгээгийн Ганхуяг - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн тоног төхөөрөмжийн засварчин

10. Халтардүүгийн Даваасүрэн - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Засвар механикийн заводын хөдөлмөр хамгаалал, байгаль орчин эрхэлсэн ерөнхий инженерийн орлогч

11. Дашдаваагийн Дамдинсүрэн - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн урвалжийн хэсгийн дарга

12. Цэнд-Аюушийн Дашдорж - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Төмөр замын цехийн илчит тэрэгний машинч

13. Сэр-Одын Дончир - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Геологи-Маркшейдерийн хэсгийн мониторингийн товчооны дарга

14. Бямбажавын Дуламдорж - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн их засвар хариуцсан механик

15. Шаравын Дүгэрсүрэн - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Материал техникийн хангамжийн баазын оосорлогч

16. Иваны Жаргалсайхан - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн "Сэлэнгэ" амралтын баазын дарга

17. Дүгэржавын Лхагважав - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Цахилгаан цехийн АСУ-Энерго хэсгийн дарга

18. Дэмбэрэлийн Лхагважав - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн ээлжийн дарга

19. Төмөрбатын Лхагвасүрэн - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Засвар механикийн заводын засварын албаны дарга

20. Надмидын Мэргэнбаатар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Захиргааны үйлдвэр техникийн хэлтсийн орлогч дарга-ерөнхий технологич

21. Сэрээнэнгийн Наранцэцэг - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн инженер

22. Буянтын Нацагдорж - Орхон аймгийн радио, телевизийн "Тэнгэрийн Аургу" ХХК-ийн захирал

23. Лхамжавын Нямсүрэн - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын техник хяналтын албаны дарга

24. Хишигсүрэнгийн Олзбаатар - УБТЗ-ын Эрдэнэт өртөөний дарга

25. Дамбажавын Оюун - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Инженерийн зураг төслийн хэлтсийн товчооны дарга

26. Лувсанбалдангийн Оюунгэрэл - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Төмөр замын цехийн диспетчер

27. Адилбишийн Өлзийхуяг - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төвийн хөвүүлэн баяжуулагч

28. Батмөнхийн Сүхбат - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын жолооч

29. Баасангийн Сэлэнгэ - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны хэлтсийн инженер

30. Дарамжавын Сэлэнгэ - Орхон аймаг дахь "Онош" хувийн лабораторийн их эмч

31. Дүйнхэржавын Төмөрбаатар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Авто тээврийн байгууллагын автобусны жолооч

32. Дарьсүрэнгийн Түмэн-Өлзий - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн хаягдлын аж ахуйн хэсгийн насосны машинч

33. Дамбадаржаагийн Уламбаатар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Барилга засварын цехийн хангамжийн инженер

34. Ухнаагийн Уламнэмэх - Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

35. Дуламын Уртнасан - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн харъяа Технологийн сургуулийн үйлчлэгч

36. Лундэгийн Үзмээ - Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн

37. Самрангийн Халтар - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн чанар шалгагч

38. Янсанжавын Цогзолмаа - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн химийн төв лабораторийн лаборант

39. Дагвын Цогтбаяр - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн тэсэлгээчин

40. Дамдины Цэндээхүү - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Засвар угсралтын цехийн агааржуулах тоноглолын засварчин

41. Баатарын Цэрэндондов - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн "Уурхайчин"соёлын ордны хөгжмийн багш, удирдаач

42. Санжийн Цэрэнлхам - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Чанар хяналтын хэлтсийн лабораторийн эрхлэгч

43. Билэгтийн Энхмандах - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн

харъяа Барилга засварын "РСЦ" ХХК-ийн заслал чимэглэлчин

44. Пүрэвсүрэнгийн Энхтуяа - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн тэргүүлэх эдийн засагч

45. Доржийн Эрдэнэбат - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн цахилгаанчин

46. Шатарбалын Эрдэнэбаяр - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн өрмийн машинч

47. Долгорсүрэнгийн Эрдэнэцогт - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хөгжлийн хэлтсийн тэргүүлэх баяжуулагч-инженер

48. Лувсандамдингийн Эрдэнэцэцэг - Орхон аймаг дахь уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эдийн засагч

49. Дамдинсүрэнгийн Эрхэмбаяр - УБТЗ-ын Эрдэнэт өртөөний техник үйлчилгээний газрын мастер

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 357** | **Улаанбаатар хот**

### ОХУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын иргэн дараах хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1.Хайбула Гамулович Давлетбаев - Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн үйлдвэр техникийн хэсгийн тэргүүлэх инженер, орлогч дарга

2.Соколов Виталий Иванович - Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн ерөнхий инженер

**"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:**

1.Казанбасов Балгабай Култаевич - Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн цахилгааны засварчин

2.Токмаев Борис Александрович - Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Автотехникийн байгууллагын БелАЗ-ын жолооч

3.Тимофеев Николай Валерионович - ОХУ-ын Ленинград хотын Шинжлэх ухааны судалгаа, зураг төслийн Механобр Инжиниринг нийгэмлэгийн ерөнхий инженер

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 358** | **Улаанбаатар хот**

### Түдэвпунцагийн Нямжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, техникийн бэлэн байдлыг хангаж засвар үйлчилгээг байнга чанартай хийж, уул уурхайн орчин үеийн техник ашиглалтын дээд амжилтыг тогтоон үйлдвэрлэлийн онц чухал даалгаварт ажлыг тогтмол амжилттай гүйцэтгэж, уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа онцгой хувь нэмрийг нь үнэлж Хүдрийн ил уурхайн бульдозерчин, авто ачигчийн жолооч Түдэвпунцагийн Нямжавт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 359 | Улаанбаатар хот

### Дамчаагийн Бямбаад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Монгол–Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрийн гол үзүүлэлт болох хүдэр хүлээн авах төлөвлөгөөг биелүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэж, бутлуурыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх шинэ арга ажиллагааг нэвтрүүлж, уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа бодитой хувь нэмрийг нь үнэлж Баяжуулах фабрикийн бутлан тээвэрлэх хэсгийн конвейрын машинч, бутлуурчин Дамчаагийн Бямбаад Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 360 | Улаанбаатар хот

### Жамъянгийн Банзрагчид Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Төр захиргааны төв болон орон нутгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах үйлдвэр болон Эрдэнэт хотыг бүтээн босгох ажлыг удирдан зохион байгуулж, үндэсний аж үйлдвэрийн хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж төр, нийгмийн ахмад ажилтан Жамъянгийн Банзрагчид Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 361 | Улаанбаатар хот

### Жамъянжавын Дамдинжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Уул уурхайн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрлэлд шинэ техник технологи нэвтрүүлэн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн, уул уурхайн салбар болон үндэсний үйлдвэрлэлийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Америкийн хамтарсан "Эрдмин" ХХК-ийн ерөнхий захирал Жамъянжавын Дамдинжавт Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 362 | Улаанбаатар хот

### Тойвгоогийн Очирхуягт Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээх тухай

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, техникийн хүчин чадлыг бүрэн ашиглаж уулын цул ачих дээд амжилтыг тогтоон төлөвлөгөөг тогтмол давуулан биелүүлж, техникийн сэлбэг материалын зарцуулалтыг багасгах оновчтой санал гарган үйлдвэрлэлд нэвтрүүлж, уурхайчдын залуу үеийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Хүдрийн ил уурхайн экскаваторын машинч Тойвгоогийн Очирхуягт Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 363** | **Улаанбаатар хот**

**Цогзолын Дагвадоржид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, техникийн урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээг цаг тухайд нь чанартай хийхийн зэрэгцээ аюулгүй ажиллагаар бүрэн хангаж, молибдены баяжмал ачих ачилтын хугацааг хурдасгах санаачилга гарган ажилласнаар төлөвлөгөөг тогтмол давуулан биелүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Баяжуулах фабрикийн гүүрэн краны машинч Цогзолын Дагвадоржид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 364** | **Улаанбаатар хот**

**Гончигсүрэнгийн Пүрэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн 5 жилд 30 мянган тонн өнгөт металл хайлж, өнгөт металл болон ширмээр хийгддэг үйлдвэрийн нарийн тоноглолыг цутган хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, импортоор авдаг бүтээгдэхүүнийг хэмнэснээр үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Засвар механикийн заводын өнгөт металл хайлагч Гончигсүрэнгийн Пүрэвт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 365** | **Улаанбаатар хот**

**Зоригтын Ганбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг уулын цул гаргалт, хүдэр олборлолт, боловсруулалт, баяжмал үйлдвэрлэлтээр тогтмол давуулан биелүүлж, шинэ техник, технологи судлах, туршин нэвтрүүлэх ажлыг чадамгай удирдан зохион байгуулж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий захирлын үйлдвэрлэл эрхэлсэн орлогч Зоригтын Ганбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** | **Дугаар 366** | **Улаанбаатар хот**

**Галцогтын Галбаатарт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай**

Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн санхүү, эдийн засаг, бүртгэлийн менежмент, удирдлагын оновчтой бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, санхүүгийн төлбөр тооцооны дэвшилтэт арга ажиллагаар нэвтрүүлэн үйлдвэрлэлийн үр ашиг болон санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Санхүүгийн хэлтсийн дарга Галцогтын Галбаатарт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 367** **Улаанбаатар хот**

**Дамдингийн Цэрэннадмидад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, монгол үндэстний болон гадаад орны ардын бүжгийг мэргэжлийн өндөр түвшинд гоцлон бүжиглэж, уран бүтээлийнхээ санг баяжуулах, үндэсний бүжгийн урлагийг өөрийн орон төдийгүй гадаад оронд сурталчлах, хойч үедээ өвлүүлэх, ардын урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн "Уурхайчин" соёлын ордны бүжигчин Дамдингийн Цэрэннадмидад Монгол Улсын гавъяат жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 12 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 368** **Улаанбаатар хот**

**Монхооны Жавхлантуяад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Орон нутгийн боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, бага ангийн сурагчдын сурах, сэтгэн бодох авъяас чадварыг бүх талаар хөгжүүлэн, улс, аймгийн олимпиадуудад удаа дараа амжилттай оролцуулж, хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх, залуу багш нарын заах арга, ур чадварыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Орхон аймгийн Баян-Өндөр цогцолбор сургуулийн бага ангийн багш Монхооны Жавхлантуяад Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр** **Дугаар 30** **Улаанбаатар хот**

**Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2003 оны 35 дугаар тогтоолоор баталсан "Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм"-д дор дурдсан агуулга бүхий 1[1], 40.5, 98, 99, 100 дахь заалт, хэсэг нэмсүгэй:

1/"1[1]. Дотоодын цэргийн алба-ажиллагаа гэж улсын онц чухал объектыг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэргийг таслан зогсооход оролцох болон хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлэхээр явуулж байгаа цогцолбор ажиллагаагаар хэлнэ."

2/ "40.5. Дохиолол, теле хяналтын болон инженер, техникийн хэрэгслийг ашиглах журам, таних нэр."

3/ "Албаны бэлэн байдал

98. Анги, тусгай салбарууд тавигдсан үүргийг амжилттай биелүүлэх чадвартай байхыг албаны бэлэн байдал гэнэ.

99. Албаны бэлэн байдлын зэргийг Дотоодын цэргийн дарга тогтоож, удирдамж, төлөвлөгөөг батлана.

100. Албаны бэлэн байдлыг хангах үүргийг анги, тусгай салбарын захирагч хүлээнэ."

2. Мөн дүрмийн 2 дахь заалтын "... аврах ажилд болон" гэсний дараа "хөл хорио" гэж, дүрмийн 33 дахь заалтын "... хоногийн төлөвлөгөөнд" гэсний дараа "өнгөрсөн хоногийн цагийн байдал, зөрчил гарч болзошгүй чиглэл, хэсэг, объектын газар, оронд үзлэг хийх цаг, маршрут, албаны нохойг харуулын цэгт уях цаг," гэж, дүрмийн 54.1-ийн "... уян хатан" гэсний дараа "шуурхай" гэж, дүрмийн 61 дэх заалтын "... объектын хамгаалалтын бүсийг" гэсний дараа "дохиолол, теле хяналтын болон" гэж тус тус нэмсүгэй.

3. Дүрмийн 3 дахь заалтыг "Дотоодын ...ийн дарга нь улсын онц чухал обьектын ...аалалтад мөрдөх стандартыг тогтоож, ...гүйн арга хэмжээний зааврыг баталж, алба-...лагааг зохион байгуулах удирдамжийг хагас ...тутам гаргана." гэж, мөн дүрмийн 6 дахь заалтыг ...граалж байгаа объектын хэвийн үйл ажиллагаа ...агдсан, зөрчил илэрсэн үед объектын захиргаа, ...илцан ажиллагаатай байгууллага /нутаг ...гэрийн цагдаагийн байгууллага, зэргэлдээ ...рлах анги, салбар/-тай мэдээлэл солилцох, ...зэрийн хүч хэрэгслийг ашиглах журмыг анги, ...ай салбарын захирагч, объектын захиргаа, ...айн байгууллагын удирдлагатай хамтран ...ооно." гэж, дүрмийн 14 дэх заалтыг "Захирагч алба-ажиллагааг зохион байгуулах тухай ...двэрийг улирал бүр тушаалаар гаргах бөгөөд ...аалд дараах асуудлыг тусгана:

14.1. алба-ажиллагааны бодомж, үүрэг, ...ний биелүүлэх хугацаа, хүч хэрэгслийг ...лөрүүлэх чиглэл, ашиглах журам, албаны бэлэн ...длыг хангах арга хэмжээ;

14.2. өнгөрсөн улирлын алба-ажиллагаа, ...ийн байдалд хийсэн дүгнэлт;

14.3. салбаруудын үүрэг, тавигдсан үүргийг ...елүүлэх хугацаа, журам, хамгаалалтын инженер-...хникийн хэрэгслээр объектыг төхөөрөмжлөх, ...ний ашиглах журам;

14.4. цэргийн сахилга, дэг журмыг ...йжруулах, аюулгүйн арга хэмжээг сахиулах, бүх ...рлийн хангалтыг зохион байгуулахад тавигдах ...рэг;

14.5. хамгаалж байгаа объектын захиргаа, ...рилцан ажиллагаатай болон бусад байгууллагатай харилцан ажиллах үед тавигдах үүрэг, шаардагдах хүч хэрэгслийн тооцоо, штаб, төрөл мэргэжлийн албад харилцан ажиллах журам, цагийн байдлын мэдээг харилцан мэдээлэх журам;

14.6. удирдлага, холбооны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, холбоо харилцааны системийг тодотгох, хяналт шалгалтыг зохион байгуулах арга хэмжээ;

14.7. зэвсэг, тусгай хэрэгсэл, албаны нохой ашиглах журам;

14.8. цаашид алба-ажиллагааг зохион байгуулах бодомж." гэж, дүрмийн 15 дахь заалтыг "Алба-ажиллагааг тасралтгүй удирдлагаар хангаж, зохион байгуулах, шуурхай байдлыг хангах үүрэг бүхий шуурхай удирдлагын жижүүрийг хоног тутам томилно. Түүний ажиллах журмыг Дотоодын цэргийн дарга тогтооно." гэж, дүрмийн 51 дэх заалтыг "Үүрэг гүйцэтгэж байгаа харуул, цэргийн манааны бүрэлдэхүүнийг татан буулгах, өөрчлөлт оруулахыг Дотоодын цэргийн дарга, харуулын цэгийн байрлалд өөрчлөлт оруулахыг анги, тусгай салбарын захирагч, харуулд томилогдсон алба хаагчийг өөрчлөх асуудлыг салбарын захирагч тус тус шийдвэрлэнэ." гэж, дүрмийн 69.6-г "хамгаалалтад мөрдөх стандарт, аюулгүйн арга хэмжээний зааврыг мэдэж, мөрдөж ажиллах." гэж, мөн дүрмийн 75.2-ыг "объектод хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх болон бараа материалыг оруулах, гаргах журам;" гэж тус тус өөрчлөн найруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**...008 оны 11 дүгээр ...арын 12-ны өдөр** **Дугаар 31** **Улаанбаатар хот**

**Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ ...ь:

1. "Мянганы сорилтын гэрээний ...эрэгжилтийн бэлтгэл ажлын тухай" Засгийн газрын ...008 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 8 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монголын мянганы сорилтын сан"-гийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

**Дарга** - Монгол Улсын Ерөнхий сайд

**Гишүүд:** -Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

-Сангийн сайд;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;

-Эрүүл мэндийн сайд;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд;

-Иргэний нийгмийн төлөөлөгч;

-Иргэний нийгмийн төлөөлөгч;

-Хувийн хэвшлийн төлөөлөгч.

2. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох иргэний нийгэм болон хувийн хэвшлийн төлөөлөгч "Монголын мянганы сорилтын сан"-ийн дүрэм"-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу сонгогдоно.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** С.БАЯР

**САНГИЙН САЙД** С.БАЯРЦОГТ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр** **Дугаар 32** **Улаанбаатар хот**

**Сургалт, семинарын зохион байгуулалтыг сайжруулах тухай**

Төв, орон нутгийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, аймаг, нийслэлийн удирдах ажилтнуудыг сургалт, семинарт оролцуулах ажлыг журамлан төсвийн хөрөнгийг хэмнэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын гишүүдэд дараахь арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай:

а/ аймаг, нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх байгууллагын ажилтныг оролцуулан зохион байгуулах семинар, сургалтын талаархи саналаа /тухайн арга хэмжээнд оролцох хүний тоо, хугацаа, санхүүжүүлэх эх үүсвэр зэргийг тодорхой тусгасан/ эрхэлсэн салбарынхаа хүрээнд гарган жил бүрийн 6, 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байх;

б/ орон нутгийн байгууллагын ажилтныг заавал нийслэлд дуудахгүйгээр мэдээллийн технологийн дэвшил /телефон, теле, онлайн, зайны зэрэг/-ийг өргөн ашиглаж, зардал хэмнэх чиглэлийг баримтлан ажиллах.

2. Дараахь арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгорт үүрэг болгосугай:

а/ тухайн онд зохион байгуулах сургалт, семинарын талаар яам, Засгийн газрын агентлагаас ирүүлсэн саналыг хянан үзэж, нэгдсэн хуваарь боловсруулан аймаг, нийслэлд хүргүүлж, биелэлтэд хяналт тавих;

б/ сургалт, семинарын нэгдсэн хуваарьт зааснаас бусад арга хэмжээнд орон нутгийн ажилтнуудыг оролцуулахгүй байх;

в/ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагын зүгээс аймаг, нийслэлийн удирдах ажилтнуудыг оролцуулан зохион байгуулах хурал, семинарын талаар тухайн байгууллагын удирдлагатай харилцан тохиролцож, орон нутагт тухайн үед мэдэгдэж зохицуулалт хийж байх;

г/ төрийн бус байгууллагын шугамаар зохион байгуулах сургалт, семинар, бусад арга хэмжээнд орон нутгийн удирдлагыг оролцуулах асуудлыг тухай бүр шийдвэрлэх, эдгээр арга хэмжээнд төсвийн зардлаар оролцохыг хориглох.

3. Дараахь арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:

а/ сургалт, семинарын нэгдсэн хуваарийн биелэлтэд байнгын хяналт тавьж, төлөвлөгдсөн арга хэмжээнд ажилтнуудыг оролцуулан, тэдгээрийн томилолтын тайлан, дүнг тогтмол дүгнэж байх;

б/ гадаад оронд зохион байгуулагдах сургалт, семинарт оролцохдоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зөвшөөрөл авч, томилолтоор ажилласан дүнгээ тайлагнаж, өөр аймаг, нийслэлд ажиллахдаа тухай бүр мэдэгдэж байх;

в/ сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын болон төсвийн бусад байгууллагын ажилтнуудын дотоод, гадаад албан томилолтын жилийн хуваарийг батлан мөрдүүлж, зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд томилолт олгохгүй байх.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нутгийн захиргааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 137 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Б.ДОЛГОР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр** **Дугаар 34** **Улаанбаатар хот**

**Журамд нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам батлах тухай" Засгийн газрын 2000 оны 178 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын хуралдааны журам"-д дор дурдсан агуулгатай $3^1$ дугаар зүйл нэмсүгэй:

"$3^1$. Хуралдаанаар улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу аюул учруулахуйц газар хөдлөлт, хүчтэй салхи, шуурга, түймэр, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хордуулалт, террорист халдлага, хүн, малын гоц халдварт өвчин гарсан; улсын эдийн засаг, санхүүгийн салбарт гарч болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй зохион байгуулах шаардлага бий болсон зэрэг асуудлыг хэлэлцэхэд энэ журмын 13-16, 18-20, 22-25, 28-32 дугаар зүйлийг мөрдөхгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөлд Засгийн газрын гишүүний саналыг бичгээр буюу факсаар, эсхүл цахим хэлбэрээр авч болно.".

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **Б.ДОЛГОР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр** **Дугаар 37** **Улаанбаатар хот**

**Хөрөнгө гаргах тухай**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Паралимпийн XIII наадмаас шагнал авсан тамирчны мөнгөн шагнал, өвлийн спортын зарим төрлөөр олимпид оролцох эрх авах болон дэлхийн цомын төлөөх тэмцээнд оролцох тамирчдын зардал, 2008 он дуусталх хугацаанд үндэсний шигшээ багийн тамирчдад олгох цалин, нийгмийн даатгалын шимтгэлд шаардагдах 238.2 (хоёр зуун гучин найман сая хоёр зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**САНГИЙН САЙД** **С.БАЯРЦОГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

**Хэнтий аймгийн Бэрх тосгонд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Бэрх тосгонд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан тус тосгоны барилга, орон сууцны халаалтын шугам, хоолой, халаах хэрэгсэл, цэвэр, бохир усны шугам сүлжээ болон дулаан хангамжийн хөлдсөн төв шугамыг сэргээн засварлахад шаардагдах 298.6 /хоёр зуун ерэн найман сая зургаан зуун мянган/ сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

2. Барилга, орон сууцны халаалтын шугам, хоолой, халаах хэрэгсэл, дулаан хангамж, цэвэр, бохир усны шугам сүлжээ болон дулаан хангамжийн хөлдсөн төв шугамыг сэргээн засварлах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Хэнтий аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Бэрх тосгоны дулааны станц, дулааны шугам сүлжээ, цэвэр ус хангамжийн байгууламжийг хэвийн үйл ажиллагаанд орсон өдрөөс эхлэн ашиглалтыг эрхлэн хариуцах өмчлөгчийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, Төрийн өмчийн хороо /Д.Сугар/-нд даалгасугай.

4. Хэнтий аймгийн Бэрх тосгонд үүссэн нөхцөл байдалд нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоож, хариуцлага алдсан албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Долгор, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт тус тус даалгасугай.

5. Бэрх, Хөтөл, Шарын гол, Багануур, Зүүнхараа, Бор-Өндөр зэрэг суурин газрын дулааны станц, халаалтын зуух, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ хариуцсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн ашиглалт, өмчлөлийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, холбогдох аймгийн Засаг дарга, Төрийн өмчийн хороо /Д.Сугар/-нд тус тус даалгасугай.

6. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийг гаргаж тайлагнах, улсын нөөцөөс олгосон материалыг нөхөн бүрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД Д.ЗОРИГТ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Урамшуулал олгох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 227 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "60.0 (жаран)" гэснийг "80.0 (наян)" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Т.БАДАМЖУНАЙ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

### ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ НЬ:**

**1.** Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн (цаашид хууль гэх) 3 дугаар зүйлийн зарим зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.

**1.1.** Энэ зүйлийн 3.2.-т заасан өмчлөх эрхтэй холбоотой бусад эрхийн бүртгэл нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх мөн зүйлийн 3.1.-д зааснаар улсын бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд хийгдэнэ.

**1.2.** Мөн зүйлийн 3.3.-т заасан зохицуулалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13, 15 дугаар зүйлд заасан төрийн байгууллага, албан газраас гадна төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт хамаарна.

**1.3.** Энэ зүйлийн 3.4.-т заасан **"төрийн өөрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгө"** гэдэгт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх хэсэг, 16, 21, 74, 79 дүгээр зүйлүүдэд заасан аж ахуйн тооцоотой төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үл хөдлөх эд хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгөд хамаарах үл хөдлөх эд хөрөнгө гэж ойлгоно.

Мөн хэсэгт заасан **"төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагын албан ёсны тодорхойлолт"**-д Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11, 78 дугаар зүйлд заасан төрийн болон орон нутгийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагаас хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.-т заасанаар гаргаж өгсөн тодорхойлолт хамаарна.

**1.4.** Мөн зүйлийн 3.5.-д заасан **"Иргэн Газрын тухай хуулийн 52.7-д заасны дагуу эзэмшиж байгаа газар дээрээ өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан барилга байгууламж, өвөлжөө, хаваржааны хашааг өмчлөх эрх, түүнтэй холбоотой энэ хуулийн 3.2.1-3.2.4-т заасан эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж болно"** гэснийг энэ зүйлийн 3.7., Иргэний хуулийн 182 дугаар зүйлийн 182.2.-т заасан үндэслэлээр бүртгүүлэх эсэхийг тухайн эд хөрөнгийг өмчлөгч өөрөө, барьцаа, түрээс, узуфрукт, сервитутын гэрээний талууд харилцан тохиролцож болно гэж ойлгоно.

**2.** Хуулийн 4 дүгээр зүйлийн зохицуулалтыг доорх байдлаар тайлбарласугай.

**2.1.** Иргэний 1994 оны хуулийн 122 дугаар зүйлийн 2, Иргэний 2002 оны хуулийн 110 дугаар зүйлийн 110.1.-д заасаар үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх уг эрхийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсдэг тул хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасан **"өмчлөгч нь үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ энэ хуульд заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авснаар түүний өмчлөх эрх баталгаажна"** гэснийг Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай 1997 оны хуулийг дагаж мөрдөгдөхөөс өмнө буюу 1997 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө үүссэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхэд хамааруулж, уг эрхийг Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулиар улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол энэ хуулийн дагуу бүртгүүлснээр бүртгэлээс өмнө үүссэн өмчлөх эрх баталгаажна гэж ойлгоно.

**2.2.** Энэ зүйлийн 4.2.-т заасан **"Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр**

**нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид шилжиж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно"** гэдгийг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шилжүүлэх тухай хэлцлийг бүртгүүлснээр өмчлөх эрх үүсэх, дуусгавар болохыг зохицуулсан Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1. дэх хэсэгтэй холбон үзэж, улсын бүртгэлд шинэ болон хуучин өмчлөгчийн үүссэн буюу дуусгавар болсон өмчлөх эрхээс гадна, энэ эрхийг шилжүүлэх үндэслэл болсон хэлцлийг мөн бүртгүүлнэ гэж ойлговол зохино.

**2.3.** Мөн зүйлийн 4.3.-т **"үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой, энэ хуулийн 3.2-т заасан эрх нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөрт тооцогдоно"** гэж заасан нь Иргэний хуулийн 150, 151, 152, 156, 166, 318 дугаар зүйлүүдтэй уялдаа холбоотой тул эдгээр зүйлд үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн гэрээ улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болохоор зохицуулсан бол энэ зүйлд заасан эрх гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

**3.** Эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээлэл нээлттэй байх тухай хуулийн 6 дугаар зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

**3.1.** Энэ зүйлийн 6.1.-д заасан **"нээлттэй байх"** гэдэг нь мөн зүйлийн 6.2.-6.6., 7 дугаар зүйлийн 7.8., 37 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу мэдээлэл өгөх ажиллагаагаар хэрэгжих бөгөөд улсын бүртгэлд бүртгэгдсэн өмчлөх болон түүнтэй холбоотой бусад эрхийн талаар хэзээ, хэн, ямар мэдээлэл авсан талаар өмчлөгчид өөрт нь мэдээлэл өгөхийг мөн адил хамааруулна.

**3.2.** Мөн зүйлийн 6.4-т зааснаар **"өмчлөгчийн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр, оршин суугаа газар, өмчлөгч нь хуулийн этгээд бол түүний нэр, оршин байгаа газар"** зэрэг нь зөвхөн тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотойгоор бусдад өгөх мэдээлэлд тусгагдана. Харин үл хөдлөх тодорхой эд хөрөнгөтэй холбоогүйгээр зөвхөн өмчлөгч этгээдийн талаар мэдээлэл авах зорилгоор түүний өмчлөлийн эд хөрөнгийг сонирхсон явдал нь **"нээлттэй байх"** гэдэгт хамаарахгүй.

**4.** Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан **"эрхийн улсын бүртгэл үнэн зөв байх"** нь бүртгэлийн хувийн хэрэгт тусгагдсан бүх мэдээлэлд хамааралтай бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн шилжилт, хөдөлгөөнийг хувийн хэрэгт нь бичиж, хувийн дугаар бүхий тэмдгээ дарж, гарын үсэг зурж баталгаажуулсан улсын бүртгэгчийн ажиллагаа үнэн зөв байдлын баталгаа болно.

**5.** Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1.-д заасан эрхийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь **"хянан үзэх, эрх зүйн дүгнэлт өгөх"** чиг үүргийг хэрэгжүүлэхдээ мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.-т заасан эрхийн дагуу үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийг улсын бүртгэлд бүртгэсэн, бүртгэхээс татгалзсан, эсхүл мэдүүлгийг хүлээн авахаас татгалзсан нь хуульд заасан үндэслэл, журамд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, дүгнэсний эцэст энэ тухай шийдвэр гаргана.

**6.** Хуулийн 12 дугаар зүйлийн 12.7.-д заасан **"Улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэр"** гэдгийг энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.3., 7.5., 12 дугаар зүйлийн 12.6.-д заасны дагуу Эрхийн улсын бүртгэлтэй холбогдох асуудлаар улсын ерөнхий бүртгэгчийн гаргасан захиргааны акт гэж ойлгоно.

**7.** Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.1.-д заасан **"үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэйг нотолсон баримт бичиг"** гэдэгт энэ зүйлийн 13.5.2.-13.5.5.-д заасан баримтуудаас гадна тухайн этгээд уг үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй болохыг нотолсон бусад баримтуудыг мөн хамааруулна.

**8.** Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1.-д заасан **"баттай нотлох баримт байхгүй"** гэж өмчлөх эрхийг бүртгүүлэхээр бүртгэлийн байгууллагад хандсан мэдүүлэг гаргаж, уг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч мөн болохоо батлах энэ хуульд заасан баримтуудыг мэдүүлэгт хавсаргаагүй байхыг хэлнэ.

**9.** Хуулийн 15 дугаар зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласугай.

**9.1.** Мэдүүлэг болон түүнд хавсаргасан баримтыг хүлээн авсны дараа хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.-д заасан мэдүүлгийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийн аль нэг илэрвэл бүртгэлийн байгууллага энэ зүйлийн 15.4.-т заасны дагуу бүртгэхээс татгалзана.

Энэ хэсэгт заасан **"тайлбар"** гэдгийг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл хийхээс татгалзсан үндэслэлийг заасан улсын бүртгэгчийн бичгийн шийдвэр гэж ойлгоно.

**9.2.** Мөн зүйлийн 15.5.-д заасан захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх журмыг зөвхөн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан улсын бүртгэгчийн шийдвэрт хамааруулан хэрэглэнэ.

Энэ хуульд заасан улсын бүртгэлтэй холбогдсон маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ улсын бүртгэл, түүнийг үндэслэн олгосон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний асуудлыг хамт шийдвэрлэж байвал зохино.

**10.** Хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.-д **"бүртгэлийн гэрчилгээ нэгдмэл дугаартай байна"** гэж заасны дагуу мөн хэсгийн **"мэдүүлэг гаргасан огноо"** гэдгийг эрхийн улсын бүртгэлийн дугаарыг мэдүүлэг хүлээн авсан өдрөөр буюу энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.-т заасан журмын адил мэдүүлэг хүлээн авсан өдөр гэж ойлгоно.

Харин шүүх, арбитрын шийдвэрийн үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд улсын бүртгэл, гэрчилгээний нэгдмэл дугаарын зарчим үйлчлэх боловч улсын бүртгэлд бүртгүүлэх мэдүүлгийг хэзээ гаргаж, бүртгэлийн байгууллага хүлээн авснаас үл хамааран мэдүүлэг гаргасан огноог хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.-д заасны шүүх, арбитрын шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр тогтооно.

**11.** Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.-д заасан **"зайлшгүй шаардлагатай мэдээлэл"** гэдэгт мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.-д заасан зүйлүүд хамаарна.

Дээрх мэдээлэл шүүх, арбитрын шийдвэрт тусгагдаагүй хэдий ч тэдгээрийг мэдүүлэг гаргагчаас олж авах боломжгүй, эсхүл түүний өгсөн мэдээлэл үндэслэл бүхий эргэлзээ төрүүлж байвал энэ байдлыг тодруулах талаар **"хүсэлт"**-ийг ерөнхий бүртгэгч нь шүүх, арбитрын байгууллагад хандан гаргана.

Шүүх, арбитр нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох хуульд заасан журмын дагуу хүсэлтэд хариу өгнө.

**12.** Хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.-д заасан эрхийн бүртгэлд шаардлагатай мэдээлэл тухайн гэрээнд бүрэн тусгагдсан эсэх, хуульд заасны гэрээ нотариатаар гэрчлэгдсэн эсэх нь мөн зүйлийн 26.2.-т заасан **"хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байвал"** гэсэн ойлголтод хамаарна.

**13.** Хуулийн 27 дугаар зүйлийн 27.2., 27.3.-т тус тус заасан тэмдэглэл, нэмэлт тэмдэглэл зэрэг ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу гаргасан мэдүүлэгт үндэслэнэ.

**14.** Хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.-д заасан **"хуульд өөрөөр заагаагүй бол"** гэдэгт Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д заасан журам хамаарна.

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН Д.БАТСАЙХАН**

**ШҮҮГЧ Б.УНДРАХ**

**П.ЦЭЦГЭЭ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.**
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 2
☎ 329487